

## **ЗАЛУУЧУУДЫН БОЛОВСРОЛ ДАХЬ ТЭГШ БУС БАЙДАЛ НЬ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОХ НЬ**

**Ж.ЭРДЭНЭЦОГТ, МУИС-ийн Хүн Амын Сургалт Судалгааны Төвийн эрдэм шинжилгээний ажилтан, Нийгмийн ухааны магистрант.**

*Хүний нийгэмшилтийн анхдагч нэгж болох гэр бүлийн орчинд гэр бүлийн хүчирхийлэл гардгаараа гэр бүлийн гишүүдийн, үр хүүхдийн эрхийг зөрчиж байдаг сөрөг үзэгдэл юм. Тиймээс манай орны төр, засгаас баримтлах бодлого, хууль эрх зүйн актууд батлагдан хэрэгжиж байна. Тухайлбал, Гэр бүлийн тухай хууль, эрүүгийн хууль зэрэг эрх зүйн актаар зохицуулагдаж байдаг. Гэвч нийгэм дэх гэр бүлийн хүчирхийллийн арга, хэлбэр улам бүр нарийсч, шинэ арга хэлбэрээр ажиллахыг шаардах боллоо. Судалгаанаас үзэхэд нийт гэр бүлийн 78.5 нь хувь гэр бүлийн ямар нэг зөрчил гардаг гэж үзсэн байхад 12.5 хувь нь зөрчил гардаггүй гэжээ. Эндээс үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн суурь шинжтэй асуудал болжээ.*

*Дэлхийн олон улс орнууд гэр бүлийн хүчирхийллийг бууруулах талаар төсөл, хөтөлбөр, судалгаа шинжилгээ хийж байгаа бөгөөд энэ үйл ажиллагааны үр дүн нь тухайн орны нийгэм, эдийн засгийн онцлогоос шууд хамаарч байдаг. Монгол орны хувьд нийгмийн өөрчлөлтэй холбоотойгоор гарч ирсэн эдийн засгийн хямрал, боловсрол дахь хүйсийн ялгаа зэрэг хүчин зүйлс нь нийгмийн олон асуудлуудыг өөртөө агуулж байдаг. Тэр дундаа боловсрол дахь хүйсийн ялгавартай байдал нь нийгмийн сөрөг асуудлуудыг агуулдаг бөгөөд түүний нэг нь гэр бүлийн хүчирхийлэл юм.*

*Бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд гэр бүлийн хүчирхийллийг бууруулах бодлого нь онолын үндэслэлтэй, уламжлалт бус өнөөгийн нийгэм дэх гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлөх хүчин зүйлсийн бүрэн тооцсон судалгаа шинжилгээн дээр тулгуурлах нь нэн чухал юм. Манай боловсролын салбар дахь хүйсийн тэгш бус харьцаа түүнээс үүдэн гарч буй гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн томоохон асуудлыг үүсгэж байгаа нь уг ажлын гол үндэслэл болж байна.*

*Судлаач өнөөгийн нийгмийн бодит дүр төрх, онолын хандлагууд, судалгааны баримтан дээр тулгуурлан өөрийн дүгнэлт, зөвлөмжөө дэвшүүлэн тавьсан юм!*

### **I. ОРШИЛ**

Монгол улс 1990 оноос ардчилсан нийгэмд шилжсэнтэйгээр холбоотой нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санааны амьдралын хүрээнд бэрхшээлтэй олон асуудлууд тулгараад байна. (МУ-ын Засгийн Газар, НҮБХХ, 2000). Гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүл салалт, архидалт, тэнэмэл хүүхэд, өрх толгойлсон эхчүүд, амиа хорлолт, мансууруулах бодис хэрэглэх, ядуурал, ажилгүйдэл гэх мэтийн нийгмийн сөрөг үзэгдлүүд нь нэг нийгмээс нөгөөд шилжих шилжилтийн үед улам хурцадмал хэлбэрээр аль ч улс орны хувьд илрэн гарч байдаг байна.

Нийгмийн эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэснээс тухайн улс орны хөгжил дэвшил шалтгаалдаг.

Эдгээрийн дотроос гэр бүлийн хүчирхийлэл нь хүний нийгэмшилтийн анхдагч үүр болох гэр бүлийн харилцаанд оршин байдгийнхаа хувьд нэн даруй шийдвэрлүүштэй асуудал юм. Иймээс гэр бүлийн хүчирхийлэл нийгмийн асуудал болохыг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч олон талт үйл ажиллагаа явуулж эхлээд байна.

Гэр бүлийн хүчирхийллийн талаар өнөөдөр манайд төрийн болон төрийн бус олон байгууллагууд тодорхой үйл ажиллагаа явуулж, хүчирхийллийн шалтгааныг тодорхойлох, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийн эрхийг хамгаалах зорилгоор судалгааны ажлууд хийсээр байгаа ч нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл багасахгүй байна. (ЗХЖТ, Хүйсийн боловсрол, сэтгүүл, 1998).

Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах бодлогыг боловсруулахдаа юуны өмнө тодорхой онолын үндэстэй, өнөөгийн нийгмийн гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйлсийг бүрэн тооцож анхаарах нь чухал ач холбогдолтой билээ.

Тиймээс ч асуудлын учир шалтгааныг нээн илрүүлэх нь эрдэмтэн судлаач, багш, оюутнуудын өмнө тавигдаж буй зайлшгүй асуудал болоод байна.

## **II. ЗОРИЛГО**

Энэхүү ажлын зорилго нь гэр бүлийн хүчирхийлэл, түүний онцлог шинж, учир шалтгааныг онолын түвшинд тайлбарлаж, уг асуудлыг хөндсөн судалгаануудын (өмнө хийгдэж байсан) үр дүнг харьцуулах, улмаар гэр бүлийн хүчирхийллийг бууруулах зарим арга замыг тодорхойлж, зөвлөмж гаргахад оршино.

## **III. АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ**

Уг ажилд нийгмийн асуудлыг онолын хандлагуудтай уялдуулан дүн шинжилгээ хийх, судалгааны үр дүнд харьцуулалт хийх зэрэг аргуудыг ашиглалаа.

## **IV. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ НИЙГМИЙН АСУУДАЛ БОЛОХ НЬ:**

Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг бол гэр бүлийн хэн нэгэн гишүүн бусдыгаа эрхшээлдээ оруулах зорилгоор бие, сэтгэл санаа, бэлгийн болон эд хөрөнгийн гэм хор учруулах үйлдэл юм (ХЭҮТ, 2000).

Гэр бүлийн хүчирхийлэл нь өөртөө тэгш эрх, гэмт хэрэг, ёс суртахуун, эрүүл мэнд, нийгмийн асуудлуудыг агуулж байдаг учраас үүнийг нийгмийн асуудал гэж үздэг.

Нийгмийн асуудлыг өрнөдийн судлаачид дараах хандлагаар авч үздэг байна.

Үүнд:

1. Функциональ хандлага
2. Зөрчилдөөний хандлага
3. Институтийн хандлага зэрэг багтана (Б.Дорждавга, 2000).

Нөөц дутагдалтай улмаас үүдэн гардаг сөргөлдөөний үр дүн гэж үздэг функциональ хандлагаар гэр бүлийн хүчирхийллийг тайлбарлахад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч өөртөө эрх мэдэл, байр суурь статус, боловсрол дутуу байгаага мэдэрсний улмаас гэр бүлийн аль нэг гишүүнийг өөрийн эрхшээлдээ оруулах зорилготой үйлдэж буй үйлдэл нь нийгмийн асуудал болж байна.

Хувь хүн, социаль институт хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн нөхцөл байдлаас хоцорч улмаар нийгмийн организмын “эрүүл саруул” үйл ажиллагаа алдагдсанаас нийгмийн асуудал гардаг гэж үздэг нийгмийн патологийн хандлага ёсоор өнөөгийн нийгэмд эрэгтэй, эмэгтэй аль ч хүмүүс нийгмийнхээ хөгжлөө дагаж ажиллаж амьдрах чадвар дутмаг байгаагаас болж нийгмийн асуудал үүсэн бий болж байна (А.Сорокин, 1997).

Гэр бүлийн гишүүдийн боловсрол, соёл, ёс суртахууны төлөвшлийн ялгаатай байдгаас үүдэн нийгмийн суурь шинж чанартай асуудал бий болдог.

Функциональ хандлагыг баримтлагчид нийгмийн асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэж байхгүй бол нийгэм аажмаар хүнлэг бус шинжтэй болдог гэж үздэг. (Б.Дорждавга, 2000).

Зөрчилдөөний онол нь нийгмийн асуудлыг бүлгийн үнэт зүйлстэй үл нийцэх нөхцөл байдал гэж тодорхойлдог. Энэ тодорхойлолтоос үзэхэд манай залуу гэр бүлийн гишүүдийн дийлэнхи хэсэг нь өөр өөр үнэт зүйлсийн чиг баримжаалалтай байдаг. Тухайлбал, Залуу эмэгтэйчүүдийн боловсролын өндөр түвшин, эрэгтэйчүүдийн боловсролын доогуур түвшин нь гэр бүлийн харилцааны хэм хэмжээ өөрчлөгдөхөд хүргэж байна.

Дээрх хоёр хандлагаас гадна институтийн хандлага нь дүрэм журам хэм хэмжээг илүү үр дүнтэй болгохын тулд нийгмийн бүлэг, институтийн бололцоог сайжруулах асуудалд голчлон анхаардаг. Тухайлбал, хувь хүн яагаад хүчирхийлэгч болов гэдгийг судлахаасаа илүү гэр бүлийн хүчирхийллийг үүсгээд байгаа социаль институтийн үйл ажиллагаа гэр бүлийн харилцаанд нөлөөлөх нөлөөллийг авч үзэх нь илүү үр дүнтэй байх боломжтой гэж үздэг.

Нийгмийн асуудал нь өөрийн гэсэн мөн чанар, учир шалтгаантай байдаг. Монголын нөхцөлд гэр бүлийн хүчирхийллийг дараах гол үндсэн шалтгаануудад ангилан авч үзлээ.

Үүнд :

1. Нийгмийн уламжлалт тогтсон хандлага буюу эмэгтэй хүнийг үнэлэх нийгмийн үнэлэмж;
2. Эдийн засгийн байдал;
3. Хүмүүжлийн буюу гэр бүлийн орчин;
4. Залуучуудын боловсролын тэгш бус байдал зэргийг багтаав.

- **Нийгмийн уламжлалт тогтсон хандлага буюу эмэгтэй хүний үнэлэх нийгмийн үнэлэмж.**

Гэр бүлийн хүчирхийлэл нь нийгэм түүхийн гүн ул үндэстэй асуудал юм (ХЭҮТ, 1998). Уламжлалт хандлагыг дэлхий нийтийн ба монголчуудын гэсэн хоёр түвшинд энд тайлбарлая. Хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд эмэгтэйчүүдийг хүйсээр ялгаварлан дорд үзэх явдал түгээмэл байсан ба зарим улс оронд уг тэгш

бус харилцааг хуулиндаа тусган хэрэгжүүлж байсан нь саяхан билээ. Жишээлбэл Англи улс 1770 онд өөр бусадтай бэлгийн харилцаанд орсон садар эхнэрээ алж болох эрхтэйг заасан ба харин нөхрийн хувьд энэ хууль үйлчилдэггүй байв (ХЭҮТ, 2000).

Харин монголчуудын хувьд эмэгтэйчүүдийг үс урт ухаан нь богино гэж үзэх, явах, суух газрыг нь зааж дорд үзэх зэргээр эрх чөлөөг нь боогдуулж байжээ. Энэ бүхэн нь гэр бүлийн хүчирхийллийн хар түүх болон ном зохиолд бичигдэн үлдсэн ч уламжлалт энэхүү хандлага нийгмийн сэтгэл зүйд одоо хэр нь хадгалагдсаар байна.

- **Эдийн засгийн байдал**

Судалгаанаас үзэхэд эдийн засгийн байдал нь гэр бүлийн хүчирхийлэлд нөлөөлөгч хүчин зүйл болдог ч уг гэр бүл эдийн засгийн хүндрэлээс гарч чадвал гэр бүлийн хүчирхийлэл, зөрчил харьцангуй багасдаг байна.

Иймээс эдийн засгийн байдал нь гэр бүлийн хүчирхийлэл оршин байх суурь шинжтэй асуудал биш бөгөөд нийгэм, эдийн засгийн өөрчлөлтөөс гарч буй нэгэн сөрөг үр дагавар юм. Иймээс ч эдийн засгийн байдал гэдэг нь тэгш бус байдлыг бий болгож гэр бүлийн дотор эрх мэдлийн хуваарийг үүсгэх бас нэгэн хүчин зүйл болдог байна. Гэхдээ амьдралын түвшин, эдийн засгийн байдал нь дангаараа гэр бүлийн хүчирхийллийн гол үндэс болохгүй гэдэг нь тодорхой юм.

- **Хүмүүжлийн буюу гэр бүлийн орчин**

Гэр бүлийн хүчирхийллийн дарамтанд өссөн хүүхдүүд хүчирхийлэгч болон төлөвшдөг гэж зарим судлаачид үздэг ч хүчирхийлэгч гэр бүлд төлөвшиж буй хүүхдүүд нь гэр бүлийн орчин дахь хүчирхийллийг жигших, эсэргүүцэх хандлагатай байдаг (ЗХЖТ, 1998).

Судалгаанаас үзэхэд гэр бүлийн хүчирхийлэлд хүүхдүүд өртөх хандлага нь харьцангуй багасах төлөвтэй байна.

Онолын хувьд функцианаль хандлагын хувьд авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийг хүн төрөлхтөний гаж үйлдэлтэй холбон авч үздэг бөгөөд тэрхүү гаж үйлдлийг дараагийн үеийнхэнд үлдээхийг хүсэж байдаг. Энэхүү байдлын уг хандлагыг баримтлагчид нийгмийн ёс зүйг өөрчилж, хүн амын боловсролыг хүйсийн хувьд тэгш байдлаар дээшлүүлснээр гэр бүлийн хүчирхийллийг тодорхой хэмжээнд шийдвэрлэх боломжтой гэж үздэг байна.

Гэр бүлийн хүчирхийллийг үүсгэх шалтгаануудаас өөр олон хүчин зүйл байдаг. Гэвч тэр бүр нь өнөөгийн бодит байдалтай уялдсан шалтгаан болж чадахгүй юм. Гэхдээ гэр бүлийн хүчирхийлэл үүсэх тодорхой хэмжээний нөлөөлөгч хүчин зүйл болох нь тодорхой.

- **Залуучуудын боловсролын тэгш бус байдал**

Онолын хандлагуудад дүн шинжилгээ хийж үзэхэд үнэт зүйлсийн баримтлал нь гэр бүлийн хүчирхийлэл, зөрчилдөөний асуудлыг тайлбарлаж болох мэт санагдаж байна. Учир нь бүлгийн үнэт зүйлстэй нийцэхгүй нөхцөл

байдал бол нийгмийн асуудал гэж тайлбарладаг бөгөөд гэр бүлийн гишүүдийн амгалан тайван байдал, дотно харилцаа, ураг төрлийн холбоог бусниулах гэр бүлийн хүчирхийлэл яах аргагүй гэмт хэргийн шинжтэй, сөрөг үр дагавартай нийгмийн асуудал болж байна.

Гэр бүлийн гишүүдийн боловсрол үнэт зүйлсийн баримжаалал нь харилцан бие биэндээ хүлээн зөвшөөрөгдсөн, нэгдмэл тогтвортой байх нь гэр бүлийн хүчирхийллийг багасгах чухал хүчин зүйл юм.

Манай улсад боловсрол олгох үйл явцад хүйсээр ялгаврлан гадуурхдаггүй ч боловсролын салбарт хүйсийн харьцаа их алдагдаж, эмэгтэйчүүд давамгайлах байдал ажиглагдаж байна (ЭМСТ,1997). Иймээс ч өнөөдөр залуучуудын боловсрол дахь хүйсийн тэнцвэргүй байдал нь нийгмийн шинжтэй суурь асуудал болоод байна (Х.Гүндсамбуу, Г.Чулуунбаатар, 1998).

2000 онд Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төвөөс явуулсан “Монголын залуучуудын жендэрийн байдал” 2000, судалгааны үр дүнгээс харахад (Хүснэгт 1-ийг харна уу)

**Хүснэгт 1. Залуучуудын боловсролын түвшин, хүйс, нас болон суурьшилаар.**

Үзүүлэлтүүд	Боловсролгүй/баг а		Бүрэн бус дунд		Бүрэн дунд		Тусгай Дээд		Бүгд
					э				
	эр	эм	эр	эм	эр	м	эр	эм	
Насны бүлэг									
16-19	18.5	9.6	37.7	39.7	41.1	49	2.5	1.9	100
20-24	12.8	6.8	27.8	23.5	43.8	43	15.5	26.2	100
25-29	4.1	0.6	24.6	11.7	33.5	31	37.6	57.2	100
30-35	3.7	3.1	24.1	14.4	20.9	26	51.3	56.4	100
Суурьшил									
Хөдөөгийн баг	25.7	12.6	44.6	39.4	17.8	29	11.9	19.2	100
Сум, баг аймгийн баг	8.2	3.5	31.5	21.6	36.2	37	24	38.4	100
Аймгийн төв	1	2	32	13	39	45	28	40	100
Улаанбаатар	1.6	1.2	11.2	11.6	46.8	40	40.4	47	100
Бүгд	9.8	4.9	28.3	21.7	35.2	37	26.7	36.4	100

Эх үүсвэр: ХАССТ, 2000. Монголын залуучуудын жендэрийн байдал.

16-24 насны бага боловсролтой эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс бараг 2 дахин их байна. Харин 30-аас дээш насны залуучуудад бага боловсролтой залуучуудын эзлэх хувь бага, мөн хүйсийн хувьд зөрүү бараг байхгүй байгаа нь шилжилтийн жилүүдэд сургууль завсардалтад хөвгүүд илүүтэй өртөж байсны үр дагавар гэж хэлж болохоор байна. Мөн 29-өөс дээш насны бүрэн дундаас дээш боловсрол эзэмшсэн залуучуудын хувьд хүйсийн ялгаа маш бага байхад 30-аас доош насны залуучуудын хүйсийн ялгаа маш өндөр байна.

Бага боловсролтой сумын болон хөдөөгийн эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхээс 2 дахин өндөр байна. Судалгаанд хамрагдсан хөдөөгийн багийн залуучуудын дөрөвний нэг нь огт боловсролгүй эсвэл бага боловсрол эзэмшжээ.

Улаанбаатарт бүрэн дундаас дээш боловсролтой эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хувь харьцангуй ойролцоо байхад аймаг, сумын залуучуудын хувьд хүйсийн зөрүү нэлээд байна.

Хүн Амын Сургалт Судалгааны Төвөөс 1998 онд хийсэн “Хүчирхийлэл ба хууль” сэдэвт судалгааны дүнгээс үзэхэд нийт судалгаанд оролцогчдын 90 гаруй хувь нь хүчирхийлэлд ямар нэг хэлбэрээр өртдөг гэж мэдээлсэн байна.

Гэр бүлийн зөрчил үүсдэг хамгийн гол шалтгаан нь зан араншингийн байдал (17,5), үзэл бодлын зөрүү (13,0), нөхөр архи уудаг (15,5), эдийн засгийн байдлаас (20,3) зэрэг шалтгаан гэж судалгаанд хамрагдагсад хариулжээ.

Эмэгтэйчүүдийн боловсролын түвшингээр гэр бүлийн зөрчил гарч байгаа гол шалтгааныг тодорхойлж үзэхэд бол үзэл бодлын зөрүү, ааш араншингийн зөрүү гэсэн хариултын хувь өндөр байгаа нь гэр бүлийн гишүүдийн боловсролын харилцан адилгүй байдал нь зөрчилд нөлөөлөх гол хүчин зүйл гэж үзэж болохоор байна.

Дээд боловсрол эзэмшиж буй эмэгтэйчүүд гэр бүл зохиох нь зайлшгүй бөгөөд өөрөөсөө доогуур боловсролтой эрэгтэйчүүдээс сонголт хийх болдог. Ингэснээр соёлын өөр өөр баримжаалалтай гэр бүлийн гишүүд зөрчилдөж, гэр бүлийн хүчирхийлэл үүсэхийг үгүйсгэх аргагүй юм.

Сэтгэл зүйн дарамт (57.5), эдийн засгийн хавчилга (15.8), бие махбодийн (12.5), бэлгийн харилцааны шахалтанд орох (4.8), хорьж цагдах (4.4), зэргээр хүчирхийлэлд өртдөг байна.

Хүчирхийлэлд өртөж буй хэлбэрийг нөхрийн боловсролын түвшингээр авч үзэхэд нөхөр нь бага боловсролтой эмэгтэйчүүд сэтгэл зүйн дарамтанд (72.7), нөхөр нь боловсролгүй эмэгтэйчүүд бие махбодийн дарамтанд (26.7) их өртдөг болох нь судалгаагаар нотлогджээ.

Хүчирхийлэлд өртөж буй хэлбэрийн хамгийн олон тохиолдол нь сэтгэл зүйн дарамт байгаа бөгөөд үүнд нөхөр нь боловсролгүй болон бага боловсролтой эмэгтэйчүүд илүү их өртөж байна.

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төвөөр үйлчлүүлэгчдийн (хүчирхийлэлд өртөгч) өгсөн мэдээлэлийг болон тус байгууллагын зөвөлгөө өгөгч ажилтны хөтөлсөн бүртгэлд санамсаргүй түүврийн аргаар судалсан баримтыг судалгааны дүнгээс үзэхэд дараахь үр дүн гарчээ.

**Хүснэгт 2. Хүчирхийлэлд өртөгч эмэгтэйчүүдийн боловсролын түвшин**

Боловсролын түвшин	тоо	хувь
Дээд	54	45
Тусгай дунд ба бүрэн дунд	48	40
Бүрэн бус дунд ба бага	18	15
Бүгд	120	100

Эх үүсвэр: Залуучуудын боловсролын тэгш бус байдал, түүний нийгэмд үзүүлэх нөлөө, илтгэл, 2001, Ж.Эрдэнэцогт

### Хүснэгт 3. Хүчирхийлэл үйлдэж буй эрэгтэйчүүдийн боловсролын байдал

Боловсролын түвшин	тоо	хувь
Дээд	19	15.8
Тусгай дунд ба бүрэн дунд	49	40.8
Бүрэн бус дунд ба бага	52	43.3
Бүгд	120	100

*Эх үүсвэр: Залуучуудын боловсролын тэгш бус байдал, түүний нийгэмд үзүүлэх нөлөө, илтгэл, 2001, Ж.Эрдэнэцогт*

Гэр бүлийн хүчирхийлэлд боловсролын нөлөө маш их байгааг дээрх хүснэгтүүдээс харж болно.харж байна.

Дээрх хоёр судалгаа нь түүвэрлэлт цар хүрээний хувьд харилцан адилгүй ч гарч байгаа үр дүн нэгэн нийтлэг зүйлийг баталж байна. Тухайлбал, боловсролын ялгаатай байдал, үзэл бодлын зөрүү гэсэн сонголт аль аль судалгаан дээр байгаа нь гэр бүлийн гишүүдийн статус, соёл, эрх мэдэл, үнэт зүйлсийн ялгаатай баримжаалал нь аливаа зөрчилдөөнд гол нөлөөлөгч хүчин зүйл болдог гэж үзэх зөрчилдөөний онолыг батлаж байна.

## **V. ДҮГНЭЛТ**

Өнөөгийн манай нийгэмд гарч байгаа гэр бүлийн хүчирхийлэл нь зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал биш нийгмийн шинжтэй асуудал болоод байгаа нь онолын болон судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Гэр бүлийн гишүүдийн боловсрол, үнэт зүйлсийн баримжаалал нь харилцан бие биендээ хүлээн зөвшөөрөгдсөн, нэгдмэл тогтвортой байх нь гэр бүлийн хүчирхийллийг багасгах чухал хүчин зүйл болж байна.

Нийгмийн асуудлыг авч үзэх онолын олон чиг хандлагууд гэр бүлийн хүчирхийллийн талаар хэрхэн авч үздэгийг бодлого боловсруулах түвшинд анхааран үзэх шаардлагатай юм.

Залуучуудын боловсролын тэгш бус байдлыг судлах, түүний учир шалтгаан үр дагаварыг тодорхойлж, боловсролын салбарт жендэрийн асуудлыг зөв гаргаж ирэх нь гэр бүлийн хүчирхийллийг бууруулах нэгэн гол нөхцөл болж байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь дан ганц эмэгтэйчүүдийн хувьд эрхийг хангаснаар шийдвэрлэгдэхгүй бөгөөд залуучуудын албан ба албан бус боловсрол, нийгмийн ёс суртахуун, нийгэм, эдийн засгийн бие даасан байдлыг дээшлүүлсний үр дүнд багасах боломжтой юм.

Гэр бүл гэдэг бол нийгмийн анхдагч орчин болдгийнхоо хувьд хувь хүнд боловсрол, соёлын хэм хэмжээг өвлүүлэн өгч, нийгмийн тогтвортой байдлыг хангах гол цөм болж байдаг. Иймээс гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн харилцааг тодорхойлогч шинжтэй байна.

## VI. ЗӨВЛӨМЖ

Гэр бүлийн хүчирхийллийг хэрхэн оновчтой шийдвэрлэх нь нийгэм дэх бусад сөрөг дагаварыг багасгах үндэс болдог. Иймд онолын үзэл баримтлал болон судалгааны үр дүнд үндэслэн дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Боловсрол дахь жендэрийн ялгааг багасгах;
  - Ерөнхий боловсролын сургууль дахь хүйсийн ялгааг бууруулах.
  - Сургууль завсардалтыг багасгах;
  - Эцэг эхчүүдийн үр хүүхдийнхээ боловсрол ирээдүйд оруулж буй хөрөнгө оруулалтын хандлагыг өөрчлөх боломжийг бүрдүүлэх;
2. Албан ба албан бус боловсролд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бүрэн хамруулах;
  - Албан ба албан бус боловсрол олгох, ухамсар төлөвшүүлэх, зан үйлийг өөрчлөх сургалт явуулах;
  - Төрийн болон төрийн бус байгууллагууд олон нийтийн үйл ажиллагааг эрэгтэйчүүд рүү хандуулах;
  - Эрэгтэйчүүдийн боловсролд онцгой анхаарч бодлого боловсруулах түвшинд шийдвэрлүүлэх;
3. Нийгмийн боловсролын тогтолцоо, соёл урлаг зэрэг хүний зан үйлийг өөрчлөх, идэвхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих;
  - Олон нийтийн мэдээлэлийн хэрэгслэлийг дэмжих, хүнлэг энэрэнгүй үзэл, нийгмийн оюуны үнэт зүйлсийн талаар сурталчилгаа хийх;
  - Нийгмийн сэтгэл зүйг өөрчлөх, сэтгэл судлалыг хөгжүүлэх.

## НОМ ЗҮЙ:

1. МУ-ын Засгийн Газар, НҮБХХ, 2000
2. МУ-ын Үндэсний Статистикийн Газар, Монгол улс дахь хүйсийн ялгаатай байдал сэдэвчилсэн судалгаа, 2002.
3. А.Батжаргал. Боловсрол ба жендэр, 2001.
4. Х.Гүндсамбуу, Г.Чулуунбаатар, Залуучууд XXI зууны босгон дээр, 1998.
5. Б.Дорждавга, Нийгмийн бодлого ба нийгмийн асуудал, 2000.
6. ХАЗССТ, Монголын залуучуудын жендэрийн байдал судалгаа, 2000.
7. ХАЗССТ, Хүчирхийлэл ба хууль сэдэвт судалгаа, 1998.
8. ХАЗССТ, Нөхөн үржихүйн эрүүл мэнд (хүчирхийлэл) хууль эрх зүйн мэдлэг сэдэвт сургалтын чанарыг үнэлэх судалгааны тайлан, 1997.
9. ЗХЖТ, Хүйсийн боловсрол, Сэтгүүл, 1998.
10. ХЭҮТ, Хүчирхийлэл дарамтыг даван туулж байгаа эмэгтэйчүүдийг сэтгэлийн тэнхээ, хүч чадалтай болгох нь, 1999.
11. ХЭҮТ, Семинар, чуулга уулзалтанд тавигдсан илтгэлүүдийн эмхтгэл, 2000.
12. ХАССТ, МХАХН, НҮБХАС, Монголын хүн амын сэтгүүл № 6, 2002.
13. ХЭҮТ. Эрчүүдийг хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх олон нийтийн ажлын анхан шатны гарын авлага, 1998, УБ.
14. ЭМСТ, Хүйсийн мэдээлэл №2, 1997, УБ.
15. А.Сорокин, Главные тенденций нашего времени, 1997, Москва
16. Ж.Эрдэнэцогт, Залуучуудын боловсролын тэгш бус байдал, түүний нийгэмд үзүүлэх нөлөө, илтгэл, 2001.